

Монгол Улс

“Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл” II шат “Төслийн мэдээ” сонин

Сэдэв

- Сурлагын хоцрогдлыг арилгах зорилгоор “Бичил төсөл” хэрэгжүүлнэ!
- Салбар комисс “Хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө” боловсруулахад анхаарах зүйлс
- Цэцэрлэгийн дотоод орчин бүрдүүлэхэд анхаарах зүйлс
- “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө” боловсруулах аргад суралцай!
- Цэцэрлэг, сургуульд хэрэгжүүлж болох үйл ажиллагаа - “Тохирох хэрэглэгдэхүүн” гэж юу вэ?
- “Булан” - Сургуулийн хэмжээнд хэрэгжүүлж болох “Олон шатлалт дэмжлэгийн тогтолцоо” -

2022 оны
1 дүгээр сар
Дугаар 2

“Төслийн мэдээ” сонин, Дугаар 2-ыг уншиж танилцсанд баярлалаа. Энэ удаагийн дугаартаа бид, салбар комиссын гишүүд болон цэцэрлэг, сургуулийн багш нарын өдөр тутмын үйл ажиллагаанд санаа өгөх мэдээллүүдийг нийтэллээ.

Сурлагын хоцрогдлыг арилгах зорилгоор “Бичил төсөл” хэрэгжүүлнэ!

Шалгарсан байгууллагуудын жагсаалт

Бичил төслийн чиглэл	Байгууллагын нэр
Харааны бэрхшээлтэй хүүхдийн цахим болон гэрийн сургалтын хэрэглэгдэхүүн	Тэгш эрх, тэгш боломж ТББ
Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн цахим болон гэрийн сургалтын хэрэглэгдэхүүн	Сонсголгүй боловсрол ТББ
Бие эрхтний бэрхшээлтэй хүүхдийн цахим болон гэрийн сургалтын хэрэглэгдэхүүн	ХБХ-ийн сэргээн засах хөгжлийн төв
Оюуны бэрхшээлтэй хүүхдийн цахим болон гэрийн сургалтын хэрэглэгдэхүүн	73-р сургууль
Сургуулийн өмнөх насны хүүхдэд явуулын сургалт зохион байгуулах	Монголын Портеж нийгэмлэг ТББ
Сургуулийн насны хүүхдэд явуулын сургалт зохион байгуулах	ХУД-ийн Насан туршийн боловсролын төв
Туслах багш ажиллуулах (Сонсголын бэрхшээлтэй хүүхдэд)	141-р сургууль
Туслах багш ажиллуулах (Харааны бэрхшээлтэй хүүхдэд)	Дохионы хэлний хэлмэрч орчуулагчдын холбоо ТББ
Туслах багш ажиллуулах (Бусад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд)	Хүний хөгжил судалгаа, сургалтын төв ТББ

Монгол Улсад шинэ хэлбэрийн коронавирусын халдвар тархалтаас сэргийлэх зорилгоор 2020 оны 1 сараас ЕБС-иудыг түр хаасан бөгөөд 2021 оны 9 сард сургууль дахин нээгдэх хүртэл танхимын хичээл сургалт бараг зохион байгуулагдаагүй. Теле хичээл болон цахим хичээлээр зайны сургалт явуулж буй ч, хүүхэд бүрийн хэрэгцээнд нийцсэн хичээл болж чадахгүй байгаагийн улмаас хүүхэд сурагчдын сурлагад ноцтой хоцрогдол гарах болсон.

Тиймд тус төслийн хүрээнд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн суралцахуйг дэмжих үүднээс 9 чиглэлийн дагуу бичил төсөл зарласан билээ. Өнгөрөгч оны намар төслийн хүсэлтүүдийг хүлээн авч, хүснэгтэд тэмдэглэсэн 9 байгууллагыг шалгаруулсан. Бичил төслүүдийг 2022 оны 5 сар хүртэл хэрэгжүүлэх бөгөөд шалгарсан байгууллагууд төслөө хэрэгжүүлж эхлээд байна.

Бичил төслийн үр дүнг, цаашид үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх зорилгоор төслийн баг бичил төслийн хэрэгжилтэд мониторинг хийж, та бүхнийг хэрэг болохуйц мэдээллээр хангах болно.

Салбар комисс “Хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө” боловсруулахад анхаарах зүйлс

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 6 сарын 173-р тогтоол “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм”-д 9 дүүрэг, 21 аймагт байгуулагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь дэмжлэг шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд кейс хэлэлцүүлэг зохион байгуулж, хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх тухай заасан.

Та бүхний боловсруулсан хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө нь зорилтот хүүхдийн зөвхөн хөгжлийн бэрхшээл болон тухайн хүүхдийн чадахгүй байгаа зүйлд төвлөрч, дасгал хөдөлгөөн, сэргээн засалтаар “Хүүхдийг өөрчлөхөд” л анхаарсан төлөвлөгөө болчихоогүй биз.

Тус төсөл нь 2021 оны 11 сард бүх салбар комисст зориулсан сургалт зохион байгуулж, аутизмтай хүүхдийн (4 настай) жишээн дээр хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө боловсруулах дадлага ажил хийсэн.

Энд үзүүлсэн хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөөнд, зорилтот хүүхдийг цэцэрлэгт хамруулахдаа “Хүүхдийг өөрчлөх” бус, орчинд нь зохицуулалт хийх, багш, ангийн хүүхдүүд, тэдний эцэг эхтэй ажиллах тухай тусгажээ. Энэ маягаар “Тохирох хэрэглэгдэхүүн (Хуудас 4-ыг үзнэ үү)”-ээр хангах явдал нь хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөөний хамгийн чухал анхаарах зүйл юм. Эргэн тойрны хүмүүсийн хандлага, орчныг нь өөрчлөх замаар зорьсон өөрчлөлтдөө хүрэх төлөвлөгөө боловсруулцаа.

Жилийн дараах зорилтдоо хүрэх тулгамдсан асуудал, хэрэгцээ шаардлага (Орлолцо болон орчинд нөлөөлөхөд анхаарах)	Дэмжлэгийн зорилт	Хүрэх хугацаа	Дэмжлэгийн агуулга (Давтамж, цаг)	Хариуцах байгууллага/хүн	
4	Цэцэрлэгийн багш нь охинтой ажиллах арга мэдэхгүй чөхөрсөн тул ангидаа байлгах дургүй	Охиныг цэцэрлэгтээ тайван байлгах орчин бүрдүүлэхийн хамт багшид нь ажиллах аргыг зааж өгөх	2022.06	(Охиныг цэцэрлэгтээ тайван байж сургахын тулд ямар орчин бүрдүүлэх вэ?) - Багшид аутизмын ойлголт өгөх, сургалт зохион байгуулах - Хүүхдийн хөгжлийн онцлогийг судлах Сургалт: • Ажиллах арга зүйг зааж өгөх • Аутизмын хүрээний эмгэгийн ойлголт өгөх • Зураг харуулж нэрлүүлэх - Дургүй зүйлийг илрүүлэх, бэлдэж өгөх - Охинд чихсэн бэлдэж өгөх, хэрэгтэй үед зүүх - Хоол толгог шалтгааныг илрүүлэх	-Цэцэрлэгийн захиргаа -БСУГ-н мэргэжилтэн -Багш, ажилчид -Дэмжлэгийн баг
5	Цэцэрлэгийн ангийн хүүхдүүд нь гэнэт чанга хаширч, хүүхдүүдийг маажиж хазадаг Амар охиноос айж, дургүйцдэг бөгөөд хүүхдүүдийн эцэг эхчүүдээс цэцэрлэгт нь голдол их ирдэг.	Охиныг цэцэрлэгтээ тайван байлгах орчин бий болгож өгөхийн зэрэгцээ ангийн хүүхдүүдэд болон эцэг эхчүүдийн ойлголтыг дээшлүүлэх.	2022.06	(Охины ангийнхаа хүүхдүүдтэй харилцах байдлыг сайжруулахын тулд ямар зохицуулалт хийх вэ?) - Эцэг эхэд ойлголт өгөх - Ангийн хүүхдүүдэд тодорхой хэмжээний ойлголт өгөх - Аутизмын тухай ойлголт өгөх - Хүүхдүүд том хүнийг дууридаг тул багш нар хандлага өөрчлөх - Хаширлах, майжих, хазах үйлдэл хийхээс өмнө өөр зүйлд анхаарлыг нь хандуулах (Багш нарын мэдлэгийг нэмэгдүүлэх, ажиллалт хийх, туршлагатай болгох)	-Цэцэрлэгийн эмч -Эмнэлгийн эмч -Захиргаа -Төр засаг, орон нутгийн засаг захиргаа -Багш -Эцэг эхийн төлөөлөл -Дэмжлэгийн баг

Дадлага ажлаар Зөвхөн аймгийн салбар комиссын боловсруулсан хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөөний хэсгээс

Цэцэрлэгийн дотоод орчин бүрдүүлэхэд анхаарах зүйлс

Цэцэрлэгийн өдөр тутмын амьдралд, бүх хүүхдэд ойлгомжтой, аливаа үйлдэл хийхэд нь тохиромжтой орчин бүрдүүлж өгөх явдал маш чухал юм. Өглөө ирээд өөрөө хувцсаа сольж чаддаггүй хүүхэд ч анги танхимд тоглоомоо хурааж эмхлэх үедээ анхаарал нь сарнихгүйгээр, хийж буй зүйлдээ төвлөрч сурдаг байна. Энд, ямар ч хүүхдийг сэтгэл тайван өдөр тутмын амьдралд оролцох боломжтой байлгахын тулд цэцэрлэгийнхээ дотоод орчныг хүртээмжтэй, тэгш хамруулдаг болгох санаа оноо, анхаарах зүйлсээс танилцуулъя!

Жишээ 1: Ангид хэрэгжүүлж болох шинэлэг санаанууд

Өдрийн хуваарийг зургаар үзүүлэх

Өглөөний уулзалт, тоглох цаг, өдрийн хоол зэрэг цагийн хуваарийн дагуу хүүхдүүд нэг газраас нөгөө рүү шилжиж байдаг. Үйл ажиллагааны дарааллыг мартсан ч асуудалгүй байхаар өдрийн хуваарийг гарган, ойлгомжтой байршуулах нь зүйтэй.



Булан гаргах

Ганцаараа чөлөөтэй тоглох, багаараа бүтээл хийх, хамтын үйл ажиллагаа гэх мэт ангид олон төрлийн үйл ажиллагаа явагддаг. Үйл ажиллагаа, зорилго тус бүрээр булан байгуулснаар хүүхдүүдэд юу хийх ёстой нь ойлгомжтой болж, хоорондоо мөргөлдөхөөс сэргийлэх боломжтой. Зөөврийн дэвсгэр, тавиур ашиглан булангийн хэлбэрийг өөрчилж, “Чөлөөт тоглоомын”, “Бүтээл хийх”, “Айл гэр болж тоглох” булан зэргээр хувааж болно.




Цонхонд хөшиг хийх

Цонхонд хөшиг хийн хааснаар хамтын үйл ажиллагаа болон бүх хүүхэд цугласан үед анхаарал төвлөрөлтийг нэмэх боломжтой. Багшийн зогсож буй хэсгийн ард эд зүйлс тавихгүй байх, эсвэл нууж, хүүхэд багшид анхаарлаа хандуулах нөхцөл бүрдүүлэх.

Ганцаараа байх орон зай

Өрөөний булан, тавилга, хаалт зэргийг ашиглан эргэн тойрон дахь дуу чимээ, харааны мэдээлэлд мэдрэмтгий хүүхэд ганцаараа амарч болох хэсгийг бий болгоорой. Ганцаараа зураг будахад тохиромжтой, хараа, сонсголоор цочролд орохоос сэргийлсэн орон зайг санал болгож байна.



Хүүхэд ойлгоход хялбар дараалал

Гутлын тавиур, хэрэгслийн тавиур, шүүгээ, цүнхний тавиур зэргийн байршлыг сонгохдоо нэрсийн дарааллаар биш, хүүхдийн өндөр, тэргэнцэртэй хүүхэд, харааны бэрхшээлтэй хүүхэд олоход хялбар байдал зэргийг харгалзана.




Жишээ 2: Ариун цэврийн өрөөний санаа

Хүүхэд ариун цэврийн цаасаар тоглохоос сэргийлж, цаасны тохиромжтой хэмжээг хананд навал илүү ойлгомжтой болно.



Хаалган дээрээ амьтны дүрс, зургийг байрлуулж, хүүхдэд эерэг дулаан сэтгэгдэл төрүүлэх. Аль өрөөнд орох ёстойг хэлэх үед ч мөн хэрэг болно.

Хүлээх хэсгийг ойлгомжтой болгохын тулд хөлийн мөрийг шаланд наах.



Жишээ 3: Харааны мэдээлэл ашиглах

Гар угаах, хувийн бэлтгэлээ хангах дарааллыг хүүхэд цээжлээгүй байсан ч зургаар үзүүлснээр илүү ойлгомжтой болдог.



Гутлаа солих		Гараа угаацгаая!		
Малгай		1	2	3
Хувцсаа солих		Гарын алга	Гарын ар тал	Хумс
Гараа угаах		4	5	6
		Хурууны завсар	Эрхий хуруу	Бугуй

Цэцэрлэгтээ ирсний дараа хийх зүйлсийн дараалал. Үг болон зургаар илэрхийлэх нь илүү ойлгомжтой.

Гар угаах дараалал. Угаалтуурны дээр нааснаар хүүхэд харангаа гараа угааж болно.

“Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө” боловсруулах аргад суралцай!

Уншигч та бүхний дунд ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулж ажилладаг багш олон бий гэж бодож байна. Хүүхдийн бодит байдлыг яаж судлахаа мэдэхгүй, урт хугацааны зорилтоо хэрхэн дэвшүүлэхээ мэдэхгүй зэрэг асуудалтай тулгарч байна уу? 2018 оны 3 сард БСШУС-ын сайдын А/155 дугаар тушаалаар ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний загвар, боловсруулах аргачлалын хамт батлагдсан. Бид өнөөдөр та бүхэнд ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулахад туслах зөвлөгөө өгье!

Зөвлөгөө 1: Хүүхдийн бодит байдлыг нарийн судлах & Сайн чаддаг зүйлийг нь ч тэмдэглэх!

Хүүхдийн бодит байдлыг нарийн судалж тэмдэглэхийн тулд мэдээж хүүхдээ ажиглах, мөн эцэг эх мөн урьд нь зааж байсан багш, цэцэрлэгийн багш нараас мэдээлэл цуглуулах нь чухал юм. Хэрвээ эдгээр судалгаа байхгүй АУБ ганцаар тэгсгээд бичээд өнгөрвөл тухайн хүүхдийн хэрэгцээнд нийцсэн, чадварт нь тохирсон зорилт дэвшүүлж, дэмжлэг үзүүлэх хэлэлцүүлэг хийж чадахгүйд хүрнэ. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний загварт хүүхдийн бодит байдлыг “Өөртөө үйлчлэх энгийн чадвар”, “Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол”, “Нийгэмшихүй”, “Хөдөлгөөн” гэсэн 4 айд хувааж бичих байгаа. Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тухайд тусгай сургууль, ХБХ-ийн сэргээн засах хөгжлийн төвд хандан, мэргэжилтнээс зөвлөгөө авах нь үр дүнтэй.

Тус төслийн боловсруулсан “ХБХ-ийн хөгжлийн түвшинг тодорхойлох, багшлах арга зүйн гарын авлага” нь бодит байдлыг үнэлэх хэрэглэгдэхүүн болно. Оюуны бэрхшээлгүй тохиолдолд “Суралцахуйн бэрхшээлтэй зан үйлийн асуудалтай хүүхдэд дэмжлэг үзүүлэх арга зүйн зөвлөмж”-ийг мөн ашиглаарай. Эдгээр хэрэглэгдэхүүнийг баруун талын QR-аар татаж авч болно.

Бодит байдлыг “Ганцаараа бие засч чадахгүй”, “35 үсгээ уншиж чадахгүй” зэргээр чадахгүй болгоныг бичих гээд байдаг. “Бие зассаны дараа өмдөө татаж чадна”, “Найзуудтайгаа хамт дуулах дуртай” зэргээр чаддаг зүйл, дуртай зүйл, сонирхдог зүйлийг нь бичихийг хичээгээрэй. Ингэснээр урт болон богино хугацааны зорилгыг тодорхойлоход тус болно, дэмжлэг үзүүлэхэд хялбар болно.



Зөвлөгөө 2: Бодит байдлаас хэт их зөрүүтэй урт хугацааны зорилт дэвшүүлэх шаардлагагүй!

Урт хугацааг хичээлийн нэг жил гэж авч үзнэ. Зорилт нь хүүхдэд тохирч буй эсэх, тухайн ангийн зорилготой тохирч буй эсэхийг шалгана. Бэрхшээл нь хүнд, ангийн бусад хүүхдэдтэй ижил хурдаар явж чадахгүй тохиолдолд хичээл дээр хүүхдийн чадах зүйлийг бодолцож, тохирох даалгаврыг сонгох, хүрч чадах зорилтыг тодорхойлно. Жишээлбэл, 1 ба 2 тооны утгыг ойлгоогүй хүүхэд жилийн дараа 10 дотор нэмэх, хасах үйлдлийг хийж чадахгүй. Тиймээс дарааллын дагуу боломжит зорилт дэвшүүлнэ.

Зөвлөгөө 3: Урт хугацааны зорилгоо үнэлэхэд хялбар аргаар бичих!

Уртын зорилтоо биелүүлж чадсан эсэхийг хичээлийн жилийн эцэст үнэлэх шаардлагатай болдог. Тиймээс урт хугацааны зорилтоо үнэлэхэд хялбар байдлаар бичихэд анхаарах хэрэгтэй. Жишээлбэл, 35 үсгээ цээжилнэ гэсэн урт хугацааны зорилт дэвшүүлсэн гэж үзье. Хичээлийн жилийн төгсгөлд үнэлэхдээ, аль хүртэл чадаж байвал “Мэддэг болсон” бэ гэдэг нь ойлгомжгүй байгаа учраас үнэлэхэд хэцүү болчихдог. Энэ урт хугацааны зорилтыг “35 үсгээс 25-аас дээш дармал үсгийг уншиж бичиж чаддаг болно” гэж өөрчилж болох юм. Ингэвэл, үнэлэхэд ч хялбар бөгөөд хичээлийн явцад үзүүлэх дэмжлэгийнхээ талаар бодоход ч амар болно.

Зөвлөгөө 4: Богино хугацааны зорилт нь урт хугацааны зорилтдоо хүрэх жижиг алхмууд юм!

Урт хугацааны зорилтоо тодорхой болгосны дараа богино хугацааны зорилт дэвшүүлнэ. Тиймээс, улирал тус бүрийн богино хугацааны зорилт биелснээр хичээлийн жилийн эцэст уртын хугацааны зорилт биелнэ. Урт хугацааны зорилтоо хэд хэдэн жижиг алхмуудад хуваан богино хугацааны зорилтоо дэвшүүлнэ.

Богино хугацааны зорилт нь хичээл тус бүрээр задлан бичдэг. Урт хугацааны зорилтоо биелүүлэхэд чиглэсэн дэмжлэг болон хичээлээ (Бага ангийн математик, Монгол хэлний хичээл, эсвэл хичээл тарсны дараа гэх мэтчилэн) тогтсоны үндсэн дээр богино хугацааны зорилтоо бичнэ.

Богино хугацааны зорилт бүрийг биелүүлснээр урт хугацааны зорилт биелнэ!

Урт хугацааны зорилт: Дармал үсгийг нямбай бичиж сурах, түгдрэхгүй уншиж сурах

3-р улирлын зорилт: Тууш шугамтай дэвтрийн шугамыг давуулахгүйгээр дармалдаж бичиж сурна. Урт өгүүлбэрийг яаралгүй, тайван уншиж сурна.

2-р улирлын зорилт: Жижгэвтэр нүдэнд шугам давуулахгүйгээр дармалдаж бичиж сурна. Богино өгүүлбэрийг уншиж сурна.

1-р улирлын зорилт: Том нүдэнд шугам давуулахгүйгээр дармалдаж бичиж сурна. Богино өгүүлбэрийг яаралгүй, тайван уншиж сурна.

Цэцэрлэг, сургуульд хэрэгжүүлж болох үйл ажиллагаа - “Тохирох хэрэглэгдэхүүн” гэж юу вэ?

Төслийн хүрээнд БМДИ, БХ-тэй хамтран багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг сайжруулахаар ажиллаж байгаа бөгөөд цахимаар суралцах боломжтой лекцийн дүрст хичээлүүдийг бэлтгэж байна. Энэ удаад лекцийн дүрст хичээлүүдийн нэг сэдэв “Тохирох хэрэглэгдэхүүн”-ий тухай ойлголтыг танилцуулъя.

Тохирох хэрэглэгдэхүүн

НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн конвенцын 24-р зүйлд “Тодорхой тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын нэгэн адил хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг эдлэх явдлыг хангах үүднээс зохицоогүй, эсхүл үндэслэлгүй саад тогторыг арилгах, багасгахад чиглэгдсэн нэн хэрэгцээтэй бөгөөд шаардлагатай тохируулга хийх болон өөрчилж засварлахыг хэлнэ.” гэж тодорхойлжээ.

Боловсролын тохирох хэрэглэгдэхүүн гэдэг нь хөгжлийн бэрхшээлтэй болон дэмжлэг шаардлагатай хүүхдүүд суралцахад учирч буй саад бэрхшээлийг арилгах сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, нэмэлт дэмжлэг, үйлчилгээг хэлнэ. Тухайлбал, харааны бэрхшээлтэй хүүхдэд зориулан сургалтын хэрэглэгдэхүүнийг брайль үсгээр бэлтгэх, тархины саажилтын улмаас бичихдээ удаан хүүхдийн шалгалтын хугацааг уртасгах зэрэг нь тохирох хэрэглэгдэхүүн юм. Өөрөөр хэлбэл, дэмжлэг шаардлагатай хүүхдэд бусад хүүхдийн адил суралцах боломжийг сургуулийн зүгээс бүрдүүлэх хэрэгтэй.



Бусад хүүхдэд шударга бус санагдахгүй гэж үү?

Манай сургуульд илүү төсөв санхүү байхгүй л дээ...

Сургуулийн ачааллыг хэт ихэсгэх шаардлагагүй. Жишээ нь, тэргэнцэртэй хүүхдэд суралцахад цахилгаан шат суурилуулах хэрэгтэй ч өндөр өртөгтэй тул тухайн хүүхдийн ангийг нэг давхарт оруулах юм уу, шатаар өгсөж, буухад нь багш нар туслах зэргээр тохирох хэрэглэгдэхүүн бүрдүүлэх боломжтой.

Зарим хүн ганцхан хүүхдийг тохирох хэрэглэгдэхүүнээр хангачихвал бусад хүүхдэд нь шударга бус гэж боддог. Баруун талын зургийг харна уу. Энэ 3 хүүд “Бейсболын тоглолт үзэж, сэтгэгдлээ ярилцах” даалгавар өгчээ. Мэдээж тоглолтоо үзэж чадахгүй бол хоорондоо ярилцах боломжгүй. Гэтэл чулуун хана саад болоод намхан хүүхдүүд тоглолт үзэж чадахгүй байна. Баруун дээд талын зурагт үзүүлснээр бусад хүүхдүүдтэй ижилхэн гишгүүр дээр зогссон ч намхан учраас харагдахгүй. Тэгвэл баруун доод талын зурагт үзүүлсэн шиг гишгүүрийн тоог өөрчлөөд бүх хүүхдэд харагдахуйц байдлаар тохируулбал ямар вэ? Ингэснээр бүгд хамтдаа тоглолт үзэнгээ харилцан ярилцах боломжтой болно.

Эх сурвалж: <https://www.teensmoon.com/chart/>



Шударга боловч тэгш бус



Тэгш байдал

“Булан” - Сургуулийн хэмжээнд хэрэгжүүлж болох “Олон шатлалт дэмжлэгийн тогтолцоо” -


Энэ удаагийн буланд, “Олон шатлалт дэмжлэгийн тогтолцоо (Multi-Tiered System of Support)”-г танилцуулж байна. Ангийн хүүхдүүд насаар чацуу байж болох ч сурлагын түвшин, дэмжлэгийн хэрэгцээ нь харилцан адилгүй. Олон шатлалт дэмжлэгийн тогтолцоог хүүхдийн суралцахуй, нийгэмшихүйн хэрэгцээг хангах үүднээс хичээл сургалт болон дэмжлэгийн 3 шатанд хуваах бөгөөд бүх хүүхдэд чиглэсэн дэмжлэг, хичээл сургалтыг анхан шатны дэмжлэг гэж үздэг. Ангиас онцгойлон анхаарал тавих шаардлагатай хүүхдэд 2 дахь шатны дэмжлэг, тулж ажиллах, эсвэл ганцаарчлан ажиллах шаардлагатай хүүхдэд 3 дахь шатны дэмжлэг үзүүлнэ. Төслийн хүрээнд, бүх хүүхдэд чиглэсэн анхан шатны дэмжлэгийг сайтар үзүүлснээр, 2 болон 3 дахь шатны дэмжлэгийн зорилтот хүүхдүүд бие даан суралцаж, бусдын адил идэвхтэй оролцдог болгохыг зорьж байна.

Ердийн анги дахь анхан шатны дэмжлэгт анхаарах 3 гол зүйл нь, (1) Ойлгомжтой бөгөөд сонирхол төрүүлэхүйц хичээл, (2) Хүүхдийн олон төрлийн хэрэгцээг хангасан зорилт ба үнэлгээ, (3) Хүүхдэд төвтэй олон төрлийн үйл ажиллагаа юм. Дээр үзүүлсэн бейсболын зургийг дахин нэг харъя. Ханыг нь хайсаар сольчихвол яах бол? Гишгүүр тавихгүй байсан ч, хүүхдүүд тоглолт үзэх боломжтой болно биз дээ. Самбарын бичиглэлийг хуулахдаа тааруу хүүхдэд самбар дээрх агуулгыг тэмдэглэсэн цаас бэлтгэж өгөх нь ч зүгээр санаа байж болно. Хичээлийн үед өчүүхэн зүйлийг ч анхааран бэлтгэж өгснөөр, хүүхдүүдийн суралцахуйд дөхөм үзүүлэх болно.

3 дахь шат
[Дэмжлэг шаардлагатай хүүхэд]

2 дахь шат
[Анхаарал шаардлагатай хүүхэд]

Анхан шат
[Бүх хүүхэд]



Ангийн орчинд болон хичээлийн үед анхан шатны дэмжлэг үзүүлснээр илүү олон хүүхдэд аливаа үйл ажиллагаанд хамт оролцох боломж бүрдэнэ.



Анхнаас нь хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх

Эх сурвалж: <https://www.Kickboardforschools.com/mtss/what-is-multi-tiered-system-of-support-mtss/>



Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Авзага трейд бьюлдинг, 505



<https://www.facebook.com/JICA.START.2>



<https://www.jica.go.jp/project/mongolia/029/index.html>



jicastart2@gmail.com



+976-80486690
+976-95937356

